

1. ДААТГАЛЫН САЛБАРЫН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

1.1 Ерөнхий мэдээлэл

2014 оны 3 дугаар улирлын байдлаар даатгалын компани 17, даатгалын төлөөлөгч 3431, даатгалын зуучлагч компани 26, даатгалын хохирол үнэлэгч компани 19, актуарч 15, нийт 3508 тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх эзэмшигчид даатгалын салбарт үйл ажиллагаа явуулсан байна. Гадаадын хөрөнгө оруулалттай үйл ажиллагаа явуулж байгаа “Монгол даатгал” ХХК, “Ард даатгал” ХХК-иуд байна.

Хүснэгт 1

Даатгалын салбарын тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо

Үзүүлэлт	11.09.30	12.09.30	13.09.30	14.09.30
Даатгагч	17	18	17	17
<i>Даатгалын компанийн төлөөлөгчийн газар</i>			6	8
<i>Даатгалын компанийн салбар</i>	152	219	240	254
Даатгалын төлөөлөгч	2080	2436	3143	3431
Даатгалын зуучлагч	8	13	19	26
<i>Даатгалын зуучлагч компанийн салбар</i>			36	78
Даатгалын хохирол үнэлэгч	8	9	11	19
<i>Даатгалын хохирол үнэлэгч компанийн салбар</i>				22
Актуарч	12	15	15	15
Дүн	2125	2491	3205	3508

Тайлант улиралд Хорооны 2014 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 196 дугаар тогтоолоор “Соёмбо Ай Би” ХХК-д, Хорооны 2014 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 197 дугаар тогтоолоор “Худалдаа хөгжлийн банк” ХХК-д, 2014 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 237 дугаар тогтоолоор “Ваяснью солюшн” ХХК-д, Хорооны 2014 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 261 дүгээр тогтоолоор “Ар Эм Ай Би” ХХК-д тус тус даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон байна.

Хорооны 2014 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 169 дүгээр тогтоолоор “Мастер үнэлгээ” ХХК-д, Хорооны 2014 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 260 дугаар тогтоолоор “Ухаашүрт консалтинг” ХХК-д, мөн өдрийн 259 дүгээр тогтоолоор “Лэндс” ХХК-д даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус олгосон байна.


1.2 Даатгагчийн хөрөнгө

Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй 17 компанийн нийт хөрөнгийн хэмжээ 2014 оны 3 дугаар улирлын байдлаар 135.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн

үеийнхээс 12.3 тэрбум төгрөгөөр буюу 1.1 дахин өссөн байна. Эдгээрээс гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын хөрөнгийн хэмжээ 28.9 хувийг эзэлж байна. Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ сүүлийн 5 жилийн өмнөх үеийнхээс 2.9 дахин нэмэгдсэн дүнтэй байна.

Дүрслэл 1

Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ
/тэрбум төгрөгөөр/



2014 оны 3 дугаар улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан ердийн болон урт хугацааны даатгалын компаниудыг нийт хөрөнгийн хэмжээгээр нь жагсаахад эхний нэг компани 17.8 хувийг, эхний гурван компани 35.3 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 2

Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)

№	Даатгалын компаниуд	Нийт хөрөнгийн хэмжээ	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	8194,90	6,06
2	Бодь даатгал ХХК	13257,20	9,81
3	Ган зам даатгал ХХК	4387,40	3,25
4	Гэр даатгал ХХК	3810,60	2,82
5	Мандал женерал даатгал ХХК	9684,70	7,17
6	МИГ даатгал ХХК	9678,10	7,16
7	Монгол даатгал ХХК	24058,80	17,80
8	Моннис даатгал ХХК	4603,00	3,41
9	Монре даатгал ХХК	5076,60	3,76
10	Мөнх даатгал ХХК	3514,00	2,60
11	Номин даатгал ХХК	7120,20	5,27

12	Нэйшнл лайф даатгал ХХК	5856,50	4,33
13	Практикал даатгал ХХК	8147,40	6,03
14	Соёмбо даатгал ХХК	7041,50	5,21
15	Тэнгэр даатгал ХХК	10340,90	7,65
16	УБ хотын даатгал ХХК	4726,50	3,50
17	Хаан даатгал ХХК	5636,00	4,17
	Дүн	135134,3	100

Нийт хөрөнгийн бүтцийг эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн ангиллаар авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 3

Даатгалын компаниудын хөрөнгийн ангилал (сая төгрөг)

Үзүүлэлтүүд	12.09.30		13.09.30		14.09.30	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Эргэлтийн хөрөнгө	83536,90	85,06	105503,6	85,06	116352,6	86,10
Эргэлтийн бус хөрөнгө	17261,4	14,94	17138,4	14,94	18782	13,90
Нийт хөрөнгө	100798,3	100	122642	100	135134,6	100

Өмнөх оны мөн үеэс эргэлтийн хөрөнгө 10849.0 сая төгрөгөөр нэмэгдсэн буюу 1.04 пунктээр, эргэлтийн бус хөрөнгө 1643.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байдалтай байна.

1.3 Эргэлтийн хөрөнгийн бүтэц

Даатгалын салбарын нийт эргэлтийн хөрөнгө 2014 оны 3 дугаар улиралд 116.3 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 86.1 хувь, эргэлтийн бус хөрөнгө нь 18.8 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 14.0 хувийг эзэлж байгаа бол 2013 оны мөн үед эргэлтийн хөрөнгө 105.5 тэрбум төгрөгт хүрч нийт хөрөнгийн 85.0 хувь, эргэлтийн бус хөрөнгө 17.1 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 15.0 хувийг эзэлж байсан байна.

Хүснэгт 4

Даатгалын компаниудын эргэлтийн хөрөнгө (сая төгрөг)

13.09.30	12.09.30		13.09.30		14.09.30	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	47014,8	56,28	65114,2	61,72	56533,5	48,59

Богино хугацаат хөрөнгө оруулалт	23335,9	27,93	22042,5	20,89	38057,7	32,71
Дансны авлага	11002,8	13,17	15340,7	14,54	18485,2	15,89
Бусад эргэлтийн хөрөнгө	2183,4	2,61	3006,2	2,85	3276,2	2,82
Эргэлтийн хөрөнгийн дүн	83536,9	100,0	105503,6	100,0	116352,6	100,0

Эргэлтийн хөрөнгийн бүтцээр нь авч үзвэл 2014 оны 3 дугаар улиралд мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн хэмжээ 56.5 тэрбум төгрөг ба нийт эргэлтийн хөрөнгийн 48.6 хувь, богино хугацаат хөрөнгө оруулалт 38.1 тэрбум төгрөг буюу нийт эргэлтийн хөрөнгийн 32.7 хувь, дансны авлага 18.5 тэрбум төгрөг буюу нийт эргэлтийн хөрөнгийн 15.9 хувийг, бусад эргэлтийн хөрөнгө 3.3 тэрбум буюу нийт эргэлтийн хөрөнгийн 2.8 хувийг тус тус эзэлж байгаа бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс нийт эргэлтийн хөрөнгө 10.8 тэрбум төгрөгөөр буюу 1.1 хувиар нэмэгдсэн нь даатгалын компаниудийн дүрмийн сангийн нэмэгдүүлэлт болон нэмэлт хөрөнгө оруулалт татсантай холбоотой.


Өмнөх оны мөн үеийнхээс мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн хэмжээ 8.5 тэрбум төгрөгөөр буюу 13.3 хувиар буурсан ч, нийт эргэлтийн хөрөнгөнд эзлэх богино хугацаат хөрөнгө оруулалт, дансны авлагын хувийн жин 11.8 хувь ба 1.3 хувиар нэмэгдсэн байна.

1.4 Даатгагчийн өр төлбөр ба эзэмшигчдийн өмч

Даатгалын компаниудын нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчид даатгалын нөөц сан, эзэмшигчдийн өмч, өр төлбөрийн эзлэх хувь хэмжээг сүүлийн 3 жилийн 3 дугаар улирлын байдлаар харьцуулж харахад дараах байдалтай байна.

Дүрслэл 2

Даатгалын компаниудын өр төлбөр, эзэмшигчдийн өмч (хувиар)



Эзэмшигчийн өмчийн нийт өр төлбөр эзэмшигчдийн өмчид 2012 оны 3 дугаар улиралд 49.0 хувь, 2013 оны 3 дугаар улиралд 45.3 хувийг эзэлж байсан бол 2014 оны 3 дугаар улиралд 45.0 хувь болж тус тус буурсан байна. Нөгөө талаасаа нөөцийн сангийн эзлэх хувийн жин 2012 он болон 2013 оны 3 дугаар улиралд 47.0 хувь, 2014 оны мөн үед 49.0 хувь болсон нь даатгалын компаниуд уг санг нэмэгдүүлж ажилласантай холбоотой байна.


Тайлант онд нийт өр төлбөр, эзэмшигчдийн өмчид эзлэх эзэмшигчийн өмчийн дүн өмнөх оны мөн үеийнхээс 6.8 тэрбум төгрөгөөр буюу 1.1 дахин, нөөц сангийн хэмжээ 7.9 тэрбум төгрөгөөр буюу 1.1 дахин нэмэгдэж, харин өр төлбөрийн хэмжээ 2.9 тэрбум төгрөгөөр буюу 25.4 хувиар буурсан байна.

1.5 Даатгалын хураамжийн орлого

Тайлант хугацаанд даатгалын салбарын нийт хураамжийн орлогын хэмжээ 2014 оны 3 дугаар улирлын байдлаар 81.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1.2 дахин өссөн байна.

Дүрслэл 3

Даатгалын компаниудын хураамжийн орлого (тэрбум төгрөг)



Тайлант улиралд ердийн даатгалын компаниуд 80.6 тэрбум төгрөгийн, урт хугацааны даатгалын компани 1.0 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого тус тус төвлөрүүлсэн байна. Ердийн даатгалын компанийн хураамжийн орлого өмнөх оны мөн үеийнхээс 13.9 тэрбум төгрөгөөр буюу 1.2 дахин, урт хугацааны даатгалын орлого 0.3 тэрбум төгрөгөөр буюу 1.5 дахин тус тус өссөн байна. Даатгалын гэрээнүүдийн нийт үнэлгээний хэмжээ 24.6 их наяд төгрөгт хүрсэн байна. Гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын орлого нийт даатгалын хураамжийн орлогын 36.0 хувийг эзэлж байна.

Хүснэгт 5

Даатгалын хураамжийн орлого, бүтээгдэхүүнээр (сая төгрөг)

№	Даатгалын хэлбэр	13.09.30	14.09.30	Өөрчлөлт /өсөлт бууралт/
		Даатгалын орлого	нийт хураамжийн	
1	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	6649,6	7559,6	1,14
2	Хөрөнгийн даатгал	17690	23175,9	1,31
3	Автотээврийн хэрэгслийн даатгал	11930,7	14319,2	1,20
4	Ачааны даатгал	1479,3	2775,6	1,88
5	Барилга угсралтын даатгал	3774,2	948,7	0,25
6	Мал амьтдын даатгал	188,8	685,6	-
7	Агаарын хөлгийн даатгал	5457,9	4484,1	0,82
8	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	232,8	346,5	1,49
9	Хариуцлагын даатгал	5149,9	4472,5	0,87
10	Санхүүгийн даатгал	1731,8	3330,9	1,92
11	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	10774,6	14243,4	1,32
12	Зээлийн даатгал	1459	1976,8	1,35
13	Итгэлцлийн даатгал		60,7	-
14	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой Хариуцлагын даатгал	86,1	2160,7	25,10
15	Хугацаат амьдралын даатгал	265,3	201,1	0,76
16	Хуримтлалын даатгал	67,1	80,2	1,20
17	Тэтгэврийн даатгал	44,4	47,6	1,07
18	Эрүүл мэндийн даатгал	311,1	686,9	2,21
	Дүн	67292,6	81556	1.2

Даатгалын хураамжийн орлогыг даатгалын хэлбэр тус бүрээр өмнөх оны мөн үеийн үзүүлэлттэй харьцуулахад дээрх байдалтай харагдаж байна. Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал 1.14 дахин, хөрөнгийн даатгал 1.31 дахин, авто тээврийн хэрэгслийн даатгал 1.2 дахин, ачааны даатгал 1.9 дахин, авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал 1.5 дахин, санхүүгийн даатгал 1.2 дахин, жолоочийн хариуцлагын албан журмын даатгал 1.3 дахин, зээлийн даатгал 1.3 дахин, агаарын хөлгийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал 25.1 дахин, хуримтлалын даатгал 1.2 дахин, тээврийн хэрэгслийн даатгал 1.07 дахин, эрүүл мэндийн даатгал 2.2 дахин тус тус нэмэгдэж, барилга угсралтын даатгал 75.0 хувиар, агаарын хөлгийн даатгал 18.0 хувиар, хариуцлагын даатгал 13.0 хувиар, хугацаат амьдралын даатгал 24.0 хувиар тус тус буурсан байна.


2014 оны байдлаар “Монгол даатгал” ХХК 26.0 хувийг бүрдүүлсэн бол, нийт хураамжийн орлогын 52.7 хувийг эхний 3 компани бүрдүүлсэн байна.

1.6 Даатгалын нөхөн төлбөр

Тайлант хугацаанд салбарын хэмжээнд даатгалын нөхөн төлбөр 23.2 тэрбум төгрөгт хүрч, сүүлийн 5 жилийн мөн үеийнхээс 4.8 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Дүрслэл 4

Даатгалын компаниудын нөхөн төлбөр (тэрбум төгрөг)



2014 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 23.2 тэрбум төгрөгийн даатгалын нөхөн төлбөр олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс 5.8 тэрбум төгрөгөөр буюу 1.34 дахин нэмэгдсэн байна. Гадаадын болон хамтарсан хөрөнгө оруулалттай компанийн олгосон даатгалын нөхөн төлбөр нийт нөхөн төлбөрийн 40.2 хувийг эзэлж байна. Тайлант хугацааны даатгалын нөхөн төлбөрийг авч үзэхэд өмнөх оны мөн үеийнхээс гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал 1.44 дахин, авто тээврийн хэрэгслийн даатгал 1.24 дахин, барилга угсралтын даатгал 2.34 дахин, агаарын хөлгийн даатгал 12.3 дахин, хариуцлагын даатгал 2.19 дахин, санхүүгийн даатгал 3.69 дахин, жолоочийн хариуцлагын албан журмын даатгал 1.12 дахин, хугацаат амьдралын даатгал, хуримтлалын даатгал тус тус 1.1 дахин, тэтгэврийн даатгал 10.34 дахин, эрүүл мэндийн даатгал 3.6 дахин нэмэгдсэн байна.

Хүснэгт 6

Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн хэмжээ бүтээгдэхүүнээр (сая төгрөг)

№	Даатгалын хэлбэр	13.09.30	14.09.30	Өөрчлөлт /өсөлт бууралт/
		Даатгалын нийт нөхөн төлбөр		
1	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	1509,5	2 166,20	1,44
2	Хөрөнгийн даатгал	1802,7	1 434,90	0,80
3	Автотээврийн хэрэгслийн даатгал	4851,5	6 019,40	1,24
4	Ачааны даатгал	209,6	128,6	0,61
5	Барилга угсралтын даатгал	26,7	62,5	2,34
6	Мал амьтдын даатгал	57,7	19,9	0,00
7	Агаарын хөлгийн даатгал	7,7	94,7	12,30
8	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	15,2	4,20	0,00

9	Хариуцлагын даатгал	200,2	438,1	2,19
10	Санхүүгийн даатгал	417,2	1519,2	3,64
11	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	6940,4	7 798,20	1,12
12	Зээлийн даатгал	1167	3048,3	0,00
13	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал		6	
14	Хугацаат амьдралын даатгал	36,7	40,5	1,10
15	Хуримтлалын даатгал	68,4	74,9	1,10
16	Тэтгэврийн даатгал	2,9	30	10,34
17	Эрүүл мэндийн даатгал	88,2	323,3	3,6
	Дүн	17 401,60	23 208,90	1.34

Тайлант улиралд барилга угсралтын даатгал, мал амьтдын даатгалын хэлбэрээр нөхөн төлбөр олгогдоогүй байна.

Хүснэгт 7

Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн хэмжээ (сая төгрөг)

№	Даатгалын компаниуд	Нийт нөхөн төлбөр хэмжээ	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	2108,8	9,09
2	Бодь даатгал ХХК	2380,4	10,26
3	Ган зам даатгал ХХК	51,2	0,22
4	Гэр даатгал ХХК	55,8	0,24
5	Мандал женерал даатгал ХХК	1000,8	4,31
6	МИГ даатгал ХХК	1969,7	8,49
7	Монгол даатгал ХХК	7290,5	31,41
8	Моннис даатгал ХХК	32,7	0,14
9	Монре даатгал ХХК	807	3,48
10	Мөнх даатгал ХХК	168,3	0,73
11	Номин даатгал ХХК	1786,6	7,70
12	Нэйшнл лайф даатгал ХХК	468,7	2,02
13	Практикал даатгал ХХК	1860,9	8,02
14	Соёмбо даатгал ХХК	1245,2	5,37
15	Тэнгэр даатгал ХХК	1649,9	7,11
16	УБ хотын даатгал ХХК	37,2	0,16
17	Хаан даатгал ХХК	295,1	1,27
	Дүн	23208,8	100,00

Тайлант улиралд нийт даатгалын нөхөн төлбөрийн 31.41 хувийг нэг компани дангаараа эзэлсэн бөгөөд эхний 3 компани 50.8 хувийг эзэлсэн байна.

1.7 Даатгалын хохирлын харьцаа

2014 оны 3 дугаар улирлын байдлаар даатгалын хохирлын харьцаа салбарын дүнгээр 42.0 хувьд хүрч өмнөх оны мөн үеийнхээс 2.4 пунктээр нэмэгдсэн буюу сүүлийн таван жилийн мөн үеийнхээс хамгийн их түвшинд байна.

Дүрслэл 5

Даатгалын хохирлын харьцаа



Даатгалын компаниудын хохирлын харьцааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай харагдаж байна.

Хүснэгт 8

Даатгалын компаниудын хохирлын харьцаа (хувиар)

№	Даатгалын компаниуд	13.09.30	14.09.30	Өсөлт бууралт
1	Ард даатгал ХХК	34,60	37,11	2,51
2	Бодь даатгал ХХК	36,00	35,29	- 0,71
3	Ган зам даатгал ХХК	8,90	12,62	3,72
4	Гэр даатгал ХХК	31,50	19,44	- 12,06
5	Мандал женерал даатгал ХХК	27,80	37,85	10,05
6	МИГ даатгал ХХК	49,00	45,81	- 3,19
7	Монгол даатгал ХХК	49,10	51,27	2,17
8	Моннис даатгал ХХК	12,00	12,79	0,79
9	Монре даатгал ХХК	45,30	50,34	5,04
10	Мөнх даатгал ХХК	23,40	38,53	15,13
11	Номин даатгал ХХК	46,10	56,04	9,94
12	Нэйшнл лайф даатгал ХХК	28,50	46,14	17,64

13	Практикал даатгал ХХК	46,60	55,14	8,54
14	Соёмбо даатгал ХХК	51,60	34,53	- 17,07
15	Тэнгэр даатгал ХХК	35,90	38,33	2,43
16	УБ хотын даатгал ХХК	5,60	2,72	- 2,88
17	Хаан даатгал ХХК	24,70	16,00	- 8,70
	Нийт хохирлын харьцаа	40,40	42,00	

Даатгалын компаниудын хохирлын харьцааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10 компанийн үзүүлэлт өсч, 7 компанийн үзүүлэлт буурсан байна. Хамгийн өндөр хохирлын харьцаатай буюу “Ард даатгал” ХХК, “Практикал даатгал” ХХК, “Миг даатгал” ХХК, “Монре даатгал” ХХК, “Номин даатгал” ХХК-иуд тус тус 50-70 хувийн үзүүлэлттэй байна. “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн хохирлын харьцаа 3.0 хувь байна.

1.8 Даатгагчийн ашигт ажиллагаа

2014 оны 3 дугаар улирлын байдлаар даатгалын компаниуд салбарын хэмжээнд 1.6 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Нийт ердийн даатгалын 16 компани, урт хугацааны даатгалын 1 компанийн тайлант оны 3 дугаар улиралд дараах байдалтай байна.

Хүснэгт 9 Даатгалын компаниудын тайлант үеийн ашиг алдагдал (сая төгрөг)

	Даатгалын компаниуд	13.09.30	14.09.30	Өсөлт бууралт
1	Ард даатгал ХХК	2059,5	422	0,20
2	Бодь даатгал ХХК	281	28,6	0,10
3	Ган зам даатгал ХХК	385,1	500,5	1,30
4	Гэр даатгал ХХК	126,5	206,5	1,63
5	Мандал женерал даатгал ХХК	517,2	-262,6	- 0,51
6	МИГ даатгал ХХК	101,3	368,7	3,64
7	Монгол даатгал ХХК	433,5	-896,5	- 2,07
8	Моннис даатгал ХХК	222,8	43	0,19
9	Монре даатгал ХХК	80,3	73,4	0,91
10	Мөнх даатгал ХХК	110,7	3,6	0,03
11	Номин даатгал ХХК	33,9	-174,7	- 5,15
12	Нэйшнл лайф даатгал ХХК	-37,2	59,7	- 1,60
13	Практикал даатгал ХХК	73	46	0,63
14	Соёмбо даатгал ХХК	62	-258,3	- 4,17
15	Тэнгэр даатгал ХХК	599,2	756,5	1,26
16	УБ хотын даатгал ХХК	99,2	690,7	6,96
17	Хаан даатгал ХХК	-525,9	66,8	- 0,13
	Дүн	4622,1	1 673,90	3,25


Тайлант улирлын үзүүлэлтийг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад “Ган зам даатгал” ХХК 1.3 дахин, “Гэр даатгал” ХХК 1.6 дахин, “Миг даатгал” ХХК 3.64 дахин, “Тэнгэр даатгал” ХХК 1.26 дахин тус тус цэвэр ашиг нэмэгдсэн бөгөөд бусад даатгалын компаниудын хувьд буурсан үзүүлэлттэй байна. Тухайлбал “Мандал женерал даатгал” ХХК, “Монгол даатгал” ХХК, “Номин даатгал” ХХК, “Соёмбо даатгал” ХХК-иуд алдагдалтай ажилласан нь үйл ажиллагааны зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

1.9 Даатгалын нөөц сан

2014 оны 3 дугаар улирлын байдлаар даатгалын нөөцийн сангийн үзүүлэлт дараах байдалтай байна.

Дүрслэл 6

Даатгалын нөөц сан (тэрбум төгрөгөөр)



Даатгалын нөөцийн сан 2010 оны мөн үеэс хойш 2.5 дахин буюу 40.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байдалтай байна.

1.10 Давхар даатгал

2014 оны 3 дугаар улирлын байдлаар 23.2 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийг гадаадын давхар даатгалын компанид шилжүүлсэн байна.

Дүрслэл 7

Давхар даатгалын хураамж (тэрбум төгрөгөөр)



Давхар даатгалын хураамжийг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 1.26 дахин нэмэгдсэн байна. Давхар даатгалын хураамж сүүлийн таван жилийн байдлаар харахад нэмэгдэх хандлагатай байна.

Хүснэгт10

Давхар даатгалын хураамж (сая төгрөг)

№	Компанийн нэр	13.09.30	14.09.30	Өөрчлөлт
		тоо	тоо	Өсөлт бууралт
1	Ард даатгал ХХК	1181,2	1420,4	1,20
2	Бодь даатгал ХХК	2918	7443,4	2,55
3	Тэнгэр даатгал ХХК	2970,2	912,5	0,31
4	Практикал даатгал ХХК	170	119,8	0,70
5	Миг даатгал ХХК	1706,9	868,7	0,51
6	Монгол даатгал ХХК	5127	7597,2	1,48
7	Номин даатгал ХХК	36,6	216,3	5,91
8	Нэйшнл лайф даатгал ХХК	36,1	18,9	0,52
9	Мандал женерал даатгал ХХК	2883,5	3081,6	1,07
10	Соёмбо даатгал ХХК	300,6	267,7	0,89
11	Моннис даатгал ХХК	1041,8	997,4	0,96
12	Хаан даатгал ХХК		129,2	-
13	Монре даатгал ХХК	86,6	148,7	1,4
	Дүн	18458,5	23221,8	1,7

“Ард даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК “Тэнгэр даатгал” ХХК, “Монгол даатгал” ХХК, “Номин даатгал” ХХК-иудын давхар даатгалын хураамж өмнөх оны мөн үеийнхээс өсч, бусад даатгагчийн хувьд буурсан байна.

2. ЕРДИЙН ДААТГАЛ

2.1 Ердийн даатгал


Ердийн даатгалын компаниуд 2014 оны 3 дугаар улирлын байдлаар 16 даатгагч, 254 даатгалын салбар Улаанбаатар хот, хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

2.2 Ердийн даатгалын нийт хөрөнгө

Энэ оны 3 дугаар улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа 16 даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ 129.3 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 11.6 тэрбум төгрөгөөр буюу 1.1 дахин нэмэгдсэн байна.

Дүрслэл 8

Ердийн даатгалын нийт хөрөнгийн хэмжээ (тэрбум төгрөгөөр)



Сүүлийн жилүүдэд нийт хөрөнгийн хэмжээ тогтмол нэмэгдсэн нь даатгалын салбарын хөрөнгө оруулалт, хураамжийн орлого зэрэг санхүүгийн үзүүлэлт өсч байгаатай холбоотой.

2.3 Ердийн даатгалын өр төлбөр ба эзэмшигчийн өмч

Эзэмшигчийн өмчийн нийт өр төлбөр, эзэмшигчдийн өмчид эзлэх хувийн жин өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт11

Эзэмшигчдийн өмчийн үзүүлэлт (сая төгрөг)

Үзүүлэлтүүд	13.09.30		14.09.30		Өсөлт бууралт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Хувь нийлүүлсэн хөрөнгө	37833,3	73,85	46590,2	81,08	8756,9	7,23
Хуримтлагдсан ашиг, алдагдал	8274,7	16,15	6389,4	11,12	-1885,3	(5,03)
Бусад өмчийн хэсэг	5122,3	10,00	4483,2	7,80	-639,1	(2,20)
Эзэмшигчийн өмчийн дүн	51230,3	100	57462,8	100	6232,5	0

Тайлант оны 3 дугаар улирлыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад хувь нийлүүлсэн хөрөнгө 8.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, бусад өмчийн хэсэг 0.6 тэрбум төгрөгөөр, хуримтлагдсан ашиг 1.9 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

2.4 Ердийн даатгалын хураамжийн орлого

Тайлант оны 3 дугаар улиралд ердийн даатгалын компанийн хураамжийн орлого 80.6 тэрбум төгрөг, үүнээс давхар даатгалын хураамжид 23.2 тэрбум төгрөг, буцаасан даатгалд 1.9 тэрбум төгрөг шилжүүлж 55.4 тэрбум төгрөгийн цэвэр хураамжтай ажилласан байна. Даатгалын компаниудын даатгалын хураамжийн орлогыг дэлгэрэнгүй байдлаар Хүснэгт 6 -д үзүүлсэн болно.

2.5 Ердийн даатгалын нөхөн төлбөр

Тайлант оны 3 дугаар улиралд ердийн даатгалын компанийн нийт нөхөн төлбөр 22.7 тэрбум төгрөг, үүнээс орлогод тооцсон хураамжаас олгосон нөхөн төлбөр 11.6 тэрбум төгрөг, нөөц сангаас олгосон нөхөн төлбөр 11.4 тэрбум төгрөг тус тус байна. Давхар даатгагчаас 1.0 тэрбум төгрөгийг даатгалын нөхөн төлбөрт төлсөн байна. Мөн даатгалын нөхөн төлбөрийг 16361 хувь хүн, 8884 хуулийн этгээдэд тус тус олгосон байна. Даатгалын компаниудын нөхөн төлбөрийг дэлгэрэнгүй байдлаар Хүснэгт 8 -д үзүүлсэн болно.

2.6 Ердийн даатгалын хохирлын харьцаа, ашигт ажиллагаа

Тайлант оны 3 дугаар улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж байгаа ердийн даатгалын компанийн хохирлын харьцааг Хүснэгт 9-д харуулсан болно.

“Монре даатгал” ХХК нь хамгийн өндөр буюу 50.34 хувийн харьцаатай байна.

Ердийн даатгалын компаниуд тайлант оны 3 дугаар улиралд 1673.9 сая төгрөгийн хуримтлагдсан ашигтай ажилласан байна. “Мандал женерал даатгал” ХХК 262.6 сая төгрөг, “Монгол даатгал” ХХК 896.5 сая төгрөг, “Номин даатгал” ХХК 174.7 сая төгрөг, “Соёмбо даатгал” ХХК 258.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласнаар салбарын хэмжээний ашгийг бууруулахад нөлөөлсөн байна.

Компаниудын ашиг алдагдлын дэлгэрэнгүйг Хүснэгт-10 д дэлгэрэнгүй харуулсан болно.

2.7 Ердийн даатгалын нөөц сан, давхар даатгал

Тайлант оны 3 дугаар улиралд даатгалын нөөцийн сангийн үзүүлэлтийг сайн дурын даатгал, албан журмын даатгалын үзүүлэлтээр ангилж харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт12

Ердийн даатгалын нөөц сан (тэрбум төгрөг)

№	Даатгалын компаниуд	2014-III
Сайн дурын даатгал	Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн сан	25368,6
	Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан	8066,2
	Нэхэмжилсэн хохирлын нөөц сан	569,5
	Учирч болзошгүй хохирлын нөөц сан	18047,5

Албан журмын даатгал	Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн сан	9921,4
	Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан	1987,6
	Нэхэмжилсэн хохирлын нөөц сан	167,2
	Учирч болзошгүй хохирлын нөөц сан	1628,9
Нийт нөөц сангийн дүн		65756,9

Компаниудын Орлогод тооцоогүй хураамжийн нөөц 54.0 хувийг, учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан 15.2 хувийг, нэхэмжилсэн хохирлын нөөцийн сан 1.12 хувийг, учирч болзошгүй хохирлын нөөц сан 30.0 хувийг тус тус эзэлсэн байна. Ердийн даатгалын давхар даатгалын хураамжийн орлого тайлант оны 3 дугаар улиралд 23.2 тэрбум төгрөг байна. Хүснэгт 11-д харуулсан болно.


3. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛ

3.1 Урт хугацааны даатгалын хөрөнгө, эзэмшигчийн өмч

Даатгалын салбарт “Нэйшнл лайф даатгал” ХХК нь 2008 оноос хойш урт хугацааны даатгалын үйл ажиллагаа явуулж байна. Тус компанийн хөрөнгийн хэмжээ жилээс жилд нэмэгдэж ирсэн.

Дүрслэл9

Урт хугацааны даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөгөөр)




Тус компанийн нийт хөрөнгө 2010 оны мөн үеэс хойш 5.3 дахин нэмэгдсэн байна.

3.2 Урт хугацааны даатгалын хураамжийн орлого, давхар даатгал

Дүрслэл9


Урт хугацааны даатгалын компанийн нийт хураамжийн орлогын хэмжээ (сая төгрөгөөр)



Тайлант оны 3 дугаар улиралд хураамжийн орлого 1015.8 сая төгрөг болсон бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 1.5 дахин, 2010 оны мөн үеэс 6.3 дахин нэмэгдсэн байна.

Дүрслэл10

Давхар даатгал (сая төгрөг)




Давхар даатгалын хураамжид тайлант оны 3 дугаар улиралд 18.9 сая төгрөгийг төвлөрүүлсэн бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 17.2 сая төгрөгөөр, 2010 оны мөн үетэй харьцуулахад 31.7 сая төгрөгөөр буюу 2.68 дахин буурсан байна.

3.3 Даатгалын компанийн ашигт ажиллагаа, нөөц сан

Урт хугацааны даатгагчийн ашигт ажиллагаа нөөцийн санг сүүлийн таван жилийн байдлаар харуулахад дараах байдалтай байна.

Дүрслэл11

Урт хугацааны даатгалын компанийн ашигт ажиллагаа (сая төгрөг)




Тайлант үеийн 3 дугаар улиралд 59.7 сая төгрөгийн цэвэр ашигтай буюу 2 дахь улиралдаа ашигтай ажилласан байна.

Даатгагчийн нөөцийн сангийн үзүүлэлтийг харуулбал:

Дүрслэл12

Урт хугацааны даатгалын компанийн нөөц сан (сая төгрөг)



Даатгагчийн нийт орлогын хэмжээ жил бүр нэмэгдсэнтэй холбоотой нөөцийн сангийн үзүүлэлт ч нэмэгдэх хандлагатай болсон байна. 2010 оны мөн үеэс хойш 16.7 дахин нэмэгдсэн байна.

4. АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ

2014 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 16 компани жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын /цаашид “жолоочийн даатгал” гэх/ үйл ажиллагаа эрхэлж байна.

Даатгалын хураамж: 2014 оны 3 дугаар улирлын байдлаар жолоочийн даатгалын 329331 гэрээнээс нийт 14243.4 сая төгрөгийн даатгалын хураамжийн орлого төвлөрч, 2013 оны мөн үеэс 3467.0 сая төгрөгөөр буюу 1.32 дахин өссөн байна.

2012-2014 оны 3 дугаар улирлын байдлаарх жолоочийн даатгалын хураамжийн орлогыг, нийт даатгалын хураамжтай харьцуулсан үзүүлэлтийг доорх графикаар харуулж байна.

Дүрслэл 13

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын орлого (хувиар)



Даатгалын нөхөн төлбөр: 2014 оны 3 дугаар улирлын байдлаар 16522 жолоочийн даатгалын тохиолдолд нийт 7798.2 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон бөгөөд 2013 оны мөн үетэй харьцуулахад 1524.0 сая төгрөгөөр буюу 1.25 дахин өссөн байна. 2012-2014 оны 3 дугаар улирлын байдлаарх жолоочийн даатгалын нөхөн төлбөр болон даатгалын нийт нөхөн төлбөрийн үзүүлэлтийг доорх графикаар харуулж байна.

Дүрслэл 14

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр (хувиар)



Дүрслэл 15

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээнд ногдох даатгалын тохиолдлын тоо



2014 оны 3 дугаар улиралд даатгалын гэрээний тоо өмнөх оны мөн үеийнхээс 133609-оор даатгалын тохиолдлын тоо 5811-ээр тус тус нэмэгдсэн байна.

Даатгалын 100 гэрээ тутамд ногдох даатгалын тохиолдлын тоо 5 байна.

5. ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ

5.1 Даатгалын зуучлагч

Тайлант оны 3 дугаар улиралд нийт 26 даатгалын зуучлагч компани үйл ажиллагаа явуулж тайлангаа ирүүлсэн байна.

Хүснэгт 13

Компаниудын зуучлалын хураамжийн орлого (сая төгрөг)

№	Компанийн нэр	13.09.30	14.09.30	Өөрчлөлт хувь
1	“Асимон брокерс” ХХК	69,3	96,2	1,39
2	“Аме” ХХК	88,7	1,5	0,02
3	“Ачит ундарга” ХХК	34,6	101,5	2,93
4	“Лоялти солюшн” ХХК	30,9	172,5	5,58
5	“Эм жи ай би” ХХК		0	-
6	“Ренессанс групп” ХХК	55,5	40,9	0,74
8	“Тийс оф лайф” ХХК	26,3	0	-
9	“Монголиан интернэшнл брокерс” ХХК		0	-
10	“Юу ай би” ХХК		12,8	-
11	“Гэрэлт буян ундрах” ХХК		188,3	-
12	“Нэйшнл эженси” ХХК	23,5	28,6	1,22
13	“Изи инвестмент” ХХК			-
14	“Си эн эн икс” ХХК	90,3	148,6	1,65
15	“Хаан банк” ХХК	15,3	483,8	31,62
16	“Хас банк” ХХК	16,3	40,2	2,47
17	“Эрсдлийн шийдэл” ХХК	236,5	806,3	3,41
18	Төрийн банк ХХК		116,2	-
19	Эй эс ай би ХХК		0	-
20	Хүннү сэйл ХХК		7,3	-
21	Капитал банк ХХК		4,7	-
22	Сүрэг хараацай ХХК		74,3	-
23	Худалдаа хөгжлийн банк		0	-
24	Васню солюшн ХХК		2,7	
25	Ариг банк ХХК		1,8	
26	Соёмбо Ай би		4,3	-
	Дүн	687,2	2332,5	3,39

Тэмдэглэл: -үйл ажиллагаа эрхлээгүйг илэрхийлнэ.

Тайлант улиралд даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд нийт 2332.5 сая төгрөгийн даатгалын зуучлалын үйл ажиллагааны орлого төвлөрүүлсэн бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 3.4 дахин өссөн байна. Даатгалын зуучлалын хураамжийн орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад “Асимон брокерс” ХХК 1.39 дахин, “Ачит ундарга” ХХК 2.93 дахин, “Си эн эн икс” ХХК 1.65 дахин, “Лоялти солюшн” ХХК 5.58 дахин, “Нэйшнл эженси” ХХК 1.22 дахин, “Хаан банк” ХХК 31.62 дахин, “Гэрэлт буян ундрах” ХХК 19.26 дахин, “Нэйшнл эженси” ХХК 1.15 дахин, “Хас банк” ХХК 2.47 дахин, “Эрсдэлийн шийдэл” ХХК 3.41 дахин тус тус нэмэгдэж бусад даатгалын зуучлагч компаниудын орлого буурсан үзүүлэлттэй байна.


Нийт хураамжийн орлогын 35.0 хувийг “Эрсдэлийн шийдэл” ХХК нь дангаараа бүрдүүлсэн байна. “Эс ай би эс” ХХК, “Худалдаа хөгжлийн банк” ХХК-иуд нь шинээр тусгай зөвшөөрөл авсан тул даатгалын зуучлалын орлого төвлөрүүлээгүй бөгөөд “Эм жи

ай би” ХХК, “Монголиан интернэшнл брокерс” ХХК, “Пийс оф лайф” ХХК, “Изи инвестмент” ХХК-иуд тус тус орлогогүй ажилласан байна.

Даатгалын зуучлалын орлого сүүлийн 5 жилийн мөн үеийн байдалтай харьцуулахад дараах байдалтай байна.

Дүрслэл 15

Даатгалын зуучлагчийн орлого (сая төгрөгөөр)



Даатгалын зуучлагчийн орлого нь тайлантай улиралд сүүлийн 5 жилийн мөн үеийнхээс 19.67 дахин нэмэгдсэн байна.

5.2 Даатгалын хохирол үнэлэгч

Тайлантай улиралд даатгалын хохирол үнэлэгч компаниудын хохирол үнэлгээний орлого 454.0 сая төгрөгт хүрч өмнөх оны мөн үеийнхээс 2.7 дахин өссөн байна.

Хүснэгт 14

Компаниудын хохирол үнэлгээний орлого (сая төгрөг)

д/д	Компанийн нэр	13.09.30	14.09.30	Өөрчлөлт
1	“Бест эстимэйт” ХХК	23,20	14,5	0,63
2	“Гэрэгэ эстимэйт” ХХК	24,9	66,3	2,66
3	“Файн эстимэйт” ХХК	0	5	-
4	“Итгэлт эстимэйт” ХХК	36,5	36,5	-
5	“Мега марз” ХХК	9,3	7,9	-
6	“Вендо” ХХК	9,1	81,3	8,93
7	“Жи ай си си” ХХК	28,2	12,2	0,43
8	“Хөрөнгийн үнэлгээний төв” ХХК	0,3	0,6	2,00
9	Арвижих эстимэйт ХХК	9	25,7	2,86


10	Юу энд Эн	2	0	-
11	Тэгш сонголт эстимэйт	0	1	-
12	Ашид билгүүн ХХК	27,4	168,9	6,16
13	Арга билэг ХХК	0	0,3	
14	Фэйр валюшн ХХК	0	8,1	
15	Хос стандарт ХХК	0	5,2	
16	Сэлэнгэ эстимэйт ХХК	0	12,3	
17	Мастер үнэлгээ ХХК	0	4,8	
18	Лэндс ХХК	0	0,7	
19	Ухаашүрт консалтинг ХХК	0	2,7	
	Дүн	169,90	454	2.7

2014 оны 3 дугаар улирлын байдлаар даатгалын хохирол үнэлгээний орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад “Вендо” ХХК 8.93 дахин, “Гэрэгэ эстимэйт” ХХК 2.66 дахин, “Хөрөнгийн үнэлгээний төв” ХХК 2.0 дахин, “Арвижих эстимэйт” ХХК 2.86 дахин, “Ашид билгүүн” ХХК 6.16 дахин тус тус нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд “Юу энд эн” ХХК нь үйл ажиллагааны орлого төвлөрүүлээгүй байна.

Дүрслэл 16

Даатгалын хохирол үнэлгээний орлого (сая төгрөгөөр)



Даатгалын хохирол үнэлгээний орлого нь тайлант оны 3 дугаар улиралд сүүлийн 5 жилийн мөн үеийн байдлаар 5.0 дахин өссөн байна.

ДҮГНЭЛТ

Даатгалын салбарын хэмжээнд 2014 оны 3 дугаар улирлын байдлаар тусгай зөвшөөрөл эзэмшигчид 1.1 хувиар нэмэгдсэн байна. Даатгалын төлөөлөгч нийт тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчийн 98.0 хувийг эзэлж байна.

Нийт хөрөнгийн хэмжээ тайлант оны 3 дугаар улиралд 135.1 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 1.2 дахин нэмэгдсэн байна.

Даатгалын компаниудын өр төлбөр, эзэмшигчийн өмчид нөөцийн сангийн эзлэх хувь хэмжээ 49.0 хувь болж өмнөх оны мөн үеэс 3.0 пунктээр нэмэгдсэн нь даатгалын актуарын хяналт сайжирсантай холбоотой юм.

Тайлант улиралд жолоочийн хариуцлагын даатгалын хураамжийн орлого нийт даатгалын хураамжийн 18.0 хувийг эзэлж байгаа ч даатгалын нөхөн төлбөр нь нийт нөхөн төлбөрийн 34.0 хувийг эзэлж байгаа нь хохирлын харьцааг нэмэгдүүлэх хүчин зүйл болж байна. Даатгагчийн хохирлын харьцаа 42.0 хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 1.6 пунктээр нэмэгдсэн.

Тайлант оны 3 дугаар улирлын байдлаарх урт хугацааны даатгалын үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөрөнгийн хэмжээ 1.1 дахин, нөөц сан 1.13 дахин нэмэгдэж, мөн тайлант үед 59.7 сая төгрөгийн ашигтай ажилласан.

Даатгалын мэргэжлийн оролцогчдын зуучлалын үйл ажиллагааны орлого 3.4 дахин, даатгалын хохирол үнэлгээний орлого 2.7 дахин тус тус нэмэгдсэн. Арилжааны 5 банк даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авсантай холбоотой даатгалын зуучлагчийн орлого хурдацтай өсч байна.